



УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕХНИКИЙН ШААРДЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ

ТШТ: АТП

АТП-ИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Хамрах хүрээ:

Энэхүү техникийн шаардлагад өмчийн харъяаллаас үл хамааран, УБЦТС ХК-ийн эзэмшлийн түгээх сүлжээнээс тэжээгдэж буй агаарын трансформаторын дэд өртөө /АТП/-ний болон 0.4кВ-ийн самбарын плакат, хаяг бичиглэл, өнгө загварын стандарт, хэрхэн хийж гүйцэтгэх шаардлага зэрэг асуудлууд хамрагдана.

Боловсруулсан: З.Энхбаатар (ЗТТ)

Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2011 оны 4 дугаар сарын 29-ний өдрөөс

Баталсан: Техникийн асуудал эрхэлсэн дэд захирал Л.Ганзориг



Он сар өдөр:

Энэхүү тодорхойлолтыг УБЦТС ХК-ийн Техникийн Зөвлөлийн Хурлын 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан болно.



УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕХНИКИЙН ШААРДЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ

ТШТ: АТП

АТП-ИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Хамрах хүрээ:

Энэхүү техникийн шаардлагад өмчийн харъяаллаас үл хамааран, УБЦТС ХК-ийн эзэмшлийн түгээх сүлжээнээс тэжээгдэж буй агаарын трансформаторын дэд өртөө /АТП/-ний болон 0.4кВ-ийн самбарын плакат, хаяг бичиглэл, өнгө загварын стандарт, хэрхэн хийж гүйцэтгэх шаардлага зэрэг асуудлууд хамрагдана.

Боловсруулсан: З.Энхбаатар (ЗТТ)

Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2011 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс

Баталсан: Техникийн асуудал эрхэлсэн дэд захирал

Л.Ганзориг

Он сар өдөр:

Энэхүү тодорхойлолтыг УБЦТС ХК-ийн Техникийн Зөвлөлийн Хурлын 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан болно.

АГУУЛГА**ТОДОРХОЙЛОЛТ..... ХУУД.ДУГААР**

1. ХАМРАХ ХҮРЭЭ	4
2. БАРИМТАЛСАН ДҮРЭМ ЗААВРУУД.....	4
3. ДЭД СТАНЦЫН ГАДНА БИЧЛЭГИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА.....	4
3.1 0,4КВ ХУВААРИЛАХ САМБАРЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА.....	4
3.2 ЦООЖ, ЦООЖНЫ ХАМГААЛАЛТЫН БАЙДАЛ.....	4
4. АТП-НИЙ ДУГААР БОЛОН БИЧЛЭГ, ӨНГӨНИЙ ЗАГВАР.....	5
4.1 0.4КВ ХУВААРИЛАХ САМБАРЫН БИЧЛЭГ.....	5
4.2 АТП-НИЙ ДУГААРЫН БИЧИГЛЭЛ.....	6
5. ТУЛГУУРЫН ДУГААРЫГ ХИЙХ МАТЕРИАЛЫН ОНЦЛОГ	8

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү техникийн шаардлага нь өмчийн харъяаллаас үл хамааран, УБЦТС ХК-ийн эзэмшлийн түгээх сүлжээнээс тэжээгдэж буй агаарын трансформаторын дэд өртөө /АТП/-ний болон 0.4кВ-ийн самбарын плакат, хаяг бичиглэл, өнгө загварын стандарт, хэрхэн хийж гүйцэтгэх шаардлага зэрэг асуудлууд хамрагдана.

2. БАРИМТАЛСАН ДҮРЭМ ЗААВРУУД

Товчлол	Гарчиг
НСД	Нэгдсэн сүлжээний дүрэм. Дэд Бүтцийн Сайдын 2010 оны 127 тоот тушаалаар батлагдсан.
ЦБД	Цахилгаан байгууламжийн дүрэм. ДБС-ын 2003 оны 12 сарын 18-ны 252 тоот тушаалаар батлагдсан.
ТАД	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм. ДБС-ын 2003 оны 06 сарын 06-ны 125 тоот тушаал
ААД	Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм. ДБС-ын 2003 оны 12 сарын 24-ний 257 тоот тушаал
ТШТ:"ЕШН"	"Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл" Техникийн Зөвлөлийн Хурлын 2009 оны 11 сарын 25-ны өдрийн хуралдаанаар батлагдсан.
ТШТ:"0.4ХС"	"1000В хүртэлх ажиллах цахилгааны хүчний хуваарилах самбар" ТЗХ-ын 2010 оны 01 сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан.
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй. МУШУТИС. УБ.2009он

3. АТП-НИЙ 0.4КВ ХУВААРИЛАХ САМБАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 0.4КВ ХУВААРИЛАХ САМБАРЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА


АТП-ийн 0.4кВ хуваарилах самбарын эх биеийг 2.5мм-ээс багагүй зузаантай лист төмрөөр бат бөх хийж саарал өнгөөр будсан байна.

0.4кВ хуваарилах самбарын хийц болон хэлбэр хэмжээг "1000В хүртэлх хүчдэлд ажиллах цахилгаан хүчний хуваарилах самбар" техникийн шаардлагын тодорхойлолт /ТШТ: 0.4ХС/-ын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.2 ЦООЖ, ЦООЖНЫ ХАМГААЛАЛТЫН БАЙДАЛ

0.4кВ хуваарилах самбарын цоож нь нэг маягийн түлхүүрээр онгойгддог зүүдэг цоож байна. Цоожыг ус чийгэнд зэврэх, гадны нөлөөнд эвдрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор цоожны хамгаалалтын хайрцгийг хаалганд гагнаж бэхэлнэ. Хамгаалалтын хайрцгийн хэмжээ нь 150*150*150мм хэмжээтэй, 2.5мм-ээс доошгүй зузаантай лист төмөр материалаар бат бөх хийсэн байна.

Цоожны хамгаалалтын загвар:



4. АТП-НИЙ ДУГААР БОЛОН БИЧЛЭГ, ӨНГӨНИЙ ЗАГВАР

4.1 0.4КВ ХУВААРИЛАХ САМБАРЫН БИЧЛЭГ

АТП-ийн 0.4кВ хуваарилах самбарын бичлэг дор дурьдсан шаардлагуудыг хангасан буюу илүү сайн үзүүлэлттэй байх шаардлагатай.

АТП-ийн дугаарыг 0.4кВ-ийн хуваарилах самбарын хаалганы зүүн гар талын хавтасны зүүн дээд буланд хаалганы 2 ирмэгээс 100 мм зайд байрлана.

Бичиглэлийн дэвсгэр нь 500 мм урт, 140 мм өргөн, цагаан өнгөтэй байна. Дэвсгэр дээрх бичиглэл нь улаан өнгөөр бичигдсэн байна.

Дэвсгэрийн эхний хэсэгт УБЦТС ХК-ийн лого болон нэр, дэвсгэрийн гол хэсэгт АТП-ний дугаар, баруун доод буланд харилцах утасны дугаар байна.

Дугаарын үсэг болон тоог улаан өнгөөр бичнэ. Бичиглэлийн том үсэгний өндөр 85мм, өргөн 40мм, зураасны өргөн 12мм байх ба мөр хоорондын зай нь 8мм байхаар үргэжлүүлэн бичиж, тэмдэглэнэ.

АТП-ийн трансформаторын суурилагдсан хүчин чадлын бичиглэлийг 0.4кВ-ийн хуваарилах самбарын хаалганы зүүн гар талын хавтасанд доод ирмэгээс 400 мм-ийн өндөрт хавтасаа голлуулж байрлуулна.

Бичиглэлийн дэвсгэр нь 360 мм урт, 140 мм өргөн, цагаан өнгөтэй байна. Дэвсгэр дээрх бичиглэл нь улаан өнгөөр бичигдсэн байна. Дугаарын тооны


өндөр 85 мм, өргөн 40 мм ба том үсэгний өндөр 85 мм, өргөн 40 мм, жижиг үсэгний өндөр 65 мм, өргөн 30 мм, зураасны өргөн 12 мм ба үсэг хоорондын зай 5 мм байна. Мөр хоорондын зай 15 мм байна.

Аюулгүй ажиллагааны “Өндөр хүчдэл аюултай” плакатыг 0.4кВ хуваарилах самбарын хаалганы баруун гар талын хавтасанд дээд ирмэгээс 250 мм-ийн доор плакатны дээд ирмэг байхаар хавтасаа голлуулж байрлуулна.

“0.4 кВ” гэсэн бичиглэлийг 0.4 кВ хуваарилах самбарын хаалганы баруун гар талын хавтасанд аюулгүй ажиллагааны плакатны доор 100 мм-ийн доор хавтасаа голлуулж байрлуулна.

Бичиглэлийн дэвсгэр нь 280 мм урт, 140 мм өргөн, цагаан өнгөтэй байна. Бичиглэл нь улаан өнгөөр бичигдсэн байна. Бичиглэлийн том үсгийн өндөр 85 мм, өргөн 40 мм хэмжээтэй байна. Жижиг үсгийн өндөр 65 мм, өргөн 30 мм хэмжээтэй байна. Үсэг хоорондын зай 5 мм ба үсэг тоо хоорондын зай 10мм байна.

0.4кВ хуваарилах самбарын бичиглэлийн загвар:



Хэрэв 0,4кВ хуваарилах самбар нь 2 талын үйлчилгээтэй байвал самбарын 2 талд мөн адил бичиглэл болон плакатыг байрлуулна.

АТП-ийн батлагдсан зарчмын схемийг 0,4кВ хуваарилах самбарын зүүн гар талын хавтасны дотор талд А4 форматын цаасан дээр хэвлэж гялгар хавтасаар бүрж /ламинаторлаж/ байрлуулна.


4.2. АТП-НИЙ ДУГААРЫН БИЧИГЛЭЛ

1. Модон хийцтэй АТП-ийг дугаарлахдаа:

АТП-ний дугаарыг газрын түвшингөөс дээш 2м-ийн өндөрт тухайн дэд станцын модон тулгуурын бетон хөл дээр нүдэнд харагдахуйцаар байрлуулна. АТП-ний дугаарыг тавихдаа тухайн станцын дугаарыг 1-с 4 оронтой тоогоор тавина.

Бичиглэлийн дэвсгэрийн урт 360 мм, өргөн 140 мм байна. Дэвсгэрийн суурь өнгө цагаан ба бичиглэл нь улаан өнгөтэй байна. АТП-ний дугаарын тооны өндөр 85 мм, өргөн 40 мм хэмжээтэй байна. Үсэг хоорондын зай 5 мм байна.

6-10кВ хүчдэлийн модон тулгууртай АТП-ний дугаарын загвар:



Аюулгүй ажиллагааны “Бүү авир үхэл” плакатыг тухайн АТП-ний дугаарын дээд талд 100 мм-ийн зайнд байрлуулна.


2. Төмөр бетон хийцтэй агаарын дэд станцыг дугаарлахдаа:

АТП-ийн дугаарыг газрын түвшингээс дээш 2м-ийн өндөрт тухайн дэд станцын бетон тулгуурт нүдэнд харагдахуйцаар байрлуулна. АТП-ний дугаарыг тавихдаа тухайн станцын дугаарыг 1-с 4 оронтой тоогоор тавина.

Бичиглэлийн дэвсгэрийн урт 1000 мм, өргөн 110 мм байна. Дэвсгэрийн суурь өнгө цагаан ба бичиглэл нь улаан өнгөтэй байна. АТП-ний дугаарын тооны өндөр 85 мм, өргөн 40 мм хэмжээтэй байна. Үсэг хоорондын зай 5 мм байна.

Аюулгүй ажиллагааны “Бүү авир үхэл” плакатыг тухайн АТП-ний дугаарын дээд талд 100мм-ийн зайнд байрлуулна.

6-10кВ хүчдэлийн төмөр бетон тулгууртай АТП-ний дугаарын загвар:



5. ТУЛГУУРЫН ДУГААРЫГ ХИЙХ МАТЕРИАЛЫН ОНЦЛОГ

Тулгуурын дугаарыг бичиглэл болон аюулгүй ажиллагааны плакатыг 1мм-ийн зузаантай төмөр ялтасаар хийнэ. Бичиглэлийн дэвсгэрийн хэсэг болон плакатын материалыг “Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл” техникийн шаардлагын тодорхойлолт /ТШТ:ЕШН/-ын 8.2-рт заагдсны дагуу тусгай аргаар бэлтгэж, тогтоон байрлуулсан байх ёстой.

Дэвсгэрийн ирмэг нь нүцгэн гарыг ямар нэгэн байдлаар гэмтээхээргүй гөлгөр байх ёстой. Дэвсгэрийн булангуудыг 6 мм радиусаар дугуйруулсан байна. Хийцэд хэрэглэж буй ижил хэмжээтэй ган боолтууд нь ижил маркийн гангаар хийгдсэн байх ёстой.

Будагны ангилал ба индекс

АТП-ний 0,4кВ-ийн хуваарилах самбар болон дугаарын бичиглэл, аюулгүй ажиллагааны плакатын дэвсгэр болон бичиглэлийн будгийг гадаа зориулалттай төмрийн будгаар хийж гүйцэтгэнэ.

Бүх будгийн ажлыг “Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл” техникийн шаардлагын тодорхойлолт /ТШТ:ЕШН/-ийн 10-рт заагдсны дагуу хийж гүйцэтгэж тухайн заагдсан тус тус өнгөөр будна.

Бичиглэлийн бүх өнгө болон дэвсгэрийн өнгийг заасан өнгөний код дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Өнгөний код:

д/д	Өнгө нэр	Өнгөний код
1	хар	000 000
2	цагаан	FFF FFF
3	улаан	FF0 000
4	шар	FFF F00
5	саарал	808 080